



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 05

Мандалговь

А.Эрдэнэчимэгийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Адъяадоржийн Эрдэнэчимэг 55.3 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа А.Эрдэнэчимэгийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн сан хариуцсан
мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн
А.Эрдэнэчимэгийн тухай дүгнэлт**

1. А.Эрдэнэчимэг нь 1986 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 36 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2009-2012 онд Хантайшир дээд сургуулийг гааль, татварын эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2013-2014 онд Хөдөлмөрийн хэлтэст хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, 2014-2018 онд дотоод хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтнаар ажиллаж байсан.
4. А.Эрдэнэчимэгийн төрийн албаны туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ